



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Боловсролын салбарын төрийн
үйлчилгээний албан хаагчийн цалингийн
хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн "Шинжлэх ухаан, эрүүл мэнд, боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 224 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн хэмжээг нэгдүгээр, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн хэмжээг хоёрдугаар, Боловсролын сургалтын байгууллагын номын санчийн албан тушаалын цалингийн хэмжээг гуравдугаар, Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад албан тушаалын цалингийн хэмжээг дөрөвдүгээр, Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн хэмжээг тавдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид олгох илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс, гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг холбогдох Засгийн газрын тогтоолд заасан хэмжээгээр тооцож олгох, боловсролын сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, багшийн туслахад олгох нэмэгдэл хөлсийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны "Заавар батлах тухай" А/296 дугаар тушаалд заасан хэмжээгээр тус тус тооцож олгохыг төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (С.Должинсүрэн), Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Л.Төгсбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан хэмжээгээр 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагч нарт

1400010070


албан тушаалын цалинг тооцож олгохыг төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

5. Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан Боловсролын сайдын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн "Төрийн үйлчилгээний зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай" А/613 дугаартай тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  П.НАРАНБЯАР



Боловсролын сайдын 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 126 дугаар тушаалын тавдугаар хавсралт




БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА, НАСАН ТУРШИЙН
СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭРГЭЖЛИЙН
БУСАД АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Албан тушаал	Цалингийн хэмжээ
ТҮ-12	2,706,000
ТҮ-11	2,577,000
ТҮ-10	2,454,000
ТҮ-9	2,337,000
ТҮ-8	2,125,500
ТҮ-7	2,010,000
ТҮ-6	1,914,000
ТҮ-5	1,740,000
ТҮ-4	1,657,500
ТҮ-3	1,578,000
ТҮ-2	1,504,500
ТҮ-1	1,431,000

---oOo---

Боловсролын сайдын 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 1/36 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



**БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА, НАСАН ТУРШИЙН
СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭРГЭЖЛИЙН
БУСАД АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

(сард, төгрөгөөр)

Албан тушаал	Цалингийн хэмжээ
ТҮМ-7	2,338,500
ТҮМ-6	2,226,000
ТҮМ-3	1,924,500

---o0o---

Боловсролын сайдын 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 11 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



**БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН НОМЫН
САНЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

(сард, төгрөгөөр)

Албан тушаал	Цалингийн хэмжээ
ТҮСБ-3	2,121,000

---o0o---

Боловсролын сайдын 2026 оны 01 дүгээр
сарын 26-ны өдрийн 1 дугаар тушаалын
хөёрдугаар хавсралт




**МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН
ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

(сард, төгрөгөөр)

Албан тушаал	Цалингийн хэмжээ
ТҮМБ-6	2,577,000
ТҮМБ-5	2,455,500
ТҮМБ-4	2,338,500
ТҮМБ-3	2,226,000
ТҮМБ-2	2,121,000
ТҮМБ-1	1,924,500

---o0o---

Боловсролын сайдын 2026 оны 01 дүгээр
сарын 26-ны өдрийн 4 дугаар тушаалын
Нэгдүгээр хавсралт



СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Албан тушаал	Цалингийн хэмжээ
ТҮБД-5	2,455,500
ТҮБД-4	2,338,500
ТҮБД-3	2,226,000
ТҮБД-2	2,121,000
ТҮБД-1	1,924,500

---ооо---